



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (568)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Түр хороо байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2008 оны арваннэгдүгээр сарын 21 №43 (568)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

707. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай 1173

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

708. Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 08 дугаар дүгнэлтийн тухай Дугаар 32 1174
709. Түр хороо байгуулах тухай Дугаар 33 1174
710. Түр хорооны даргыг сонгох тухай Дугаар 34 1175

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

711. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 329 1175
712. Доржсүрэнгийн Мөнхбаярыг Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнах тухай Дугаар 330 1175
713. Чарлес Суонсоныг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 331 1175
714. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 333 1176
715. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 338 1176
716. Зарим хүнийг "Энхийн төлөө" медалиар шагнах тухай Дугаар 339 1181

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

717. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай Дугаар 03 1182

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсгийн "тогтоол гаргах ба шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэснийг "тогтоол гаргана" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 08 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 418 дугаар зүйлийн 418.2 дахь хэсэгт "шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй" гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй"

гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 08 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2008 оны 11 дүгээр сарын 13 -ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл"-ийг боловсронгуй болгоход чиглэгдсэн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судлан үзэж дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Түр хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- 1/ Р.Амаржаргал - Улсын Их Хурлын гишүүн
- 2/ Ц.Баярсайхан - Улсын Их Хурлын гишүүн
- 3/ Г.Баярсайхан - Улсын Их Хурлын гишүүн
- 4/ Р.Буд - Улсын Их Хурлын гишүүн
- 5/ Л.Гантөмөр - Улсын Их Хурлын гишүүн
- 6/ Д.Ганхуяг - Улсын Их Хурлын гишүүн
- 7/ Г.Занданшатар - Улсын Их Хурлын гишүүн
- 8/ Х.Наранхүү - Улсын Их Хурлын гишүүн
- 9/ Д.Одхүү - Улсын Их Хурлын гишүүн
- 10/ Д.Очирбат - Улсын Их Хурлын гишүүн
- 11/ С.Оюун - Улсын Их Хурлын гишүүн
- 12/ Ж.Сүхбаатар - Улсын Их Хурлын гишүүн

2. Түр хорооны эрхлэх асуудлын хүрээг дараахь байдлаар тогтоосугай:

1/Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл"-ийн өнөөгийн нөхцөл байдлыг судлан үзэж дүгнэлт гаргах;

2/нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд "Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл"-ийг Монгол Улсын хөгжлийн онцлогт нийцүүлэн ашиглах сул болон давуу талуудыг тодорхойлох;

3/нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хөгжүүлэх, тодорхой хугацаанд ашиглуулах, ашиглуулсны дараа төрд шилжүүлэн өгөх зэрэг бодлогын санал боловсруулах;

4/Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл"-ийг Монгол Улсад хөгжүүлэх бодлогын санал боловсруулах.

3. Дээрх асуудалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2009 оны намрын ээлжит чуулганаар Улсын Их Хуралд танилцуулахыг Түр хороонд даалгасугай.

4. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Түр хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

бүхий Улсын Их Хурлын Түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ринчиннямын Амаржаргалыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1."Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл"-ийг боловсронгуй болгоход чиглэгдсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судлан үзэж дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр

Дугаар 329

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

сайд Бямбадоржийн Гомбыг эгүүлэн татсугай.

2.Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ядамын Долгоржавыг томилсугай.

1.Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

Дугаар 330

Улаанбаатар хот

Доржсүрэнгийн Мөнхбаярыг Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнах тухай

Буудлагын спортын төрлөөр олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон олимпын их наадамд амжилттай оролцож, Монгол Улсад буудлагын спортыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын иргэн, Монгол Улсын гавъяат тамирчин Доржсүрэнгийн

Мөнхбаярыг Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

Чарлес Суонсоныг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, АНУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон манай орны боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж АНУ-ын иргэн, "Суонсоны гэр бүл сан"-гийн ерөнхийлөгч, доктор

Чарлес Суонсоныг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 333

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаа Бүгд Найрамдах Эстони Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрх

Элчин сайд Тугалхүүгийн Баасансүрэнг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаа Бүгд Найрамдах Эстони Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрх Элчин сайдаар Отгоны Дамбийнямыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, зам тээвэр, батлан хамгаалах, цагдаа, онцгой байдал, төр

захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дамдингийн Бямбаа - Зохиолч, орчуулагч, дипломатич
2. Дүлбаагийн Бямбаа - Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн дэд захирал
3. Бадарчийн Бямбабаяр - Хөгжмийн зохиолч
4. Найдансүрэнгийн Дариймаа - Хэвлэлийн хүрээлэнгийн мэдээллийн төвийн зохион байгуулагч
5. Сандагийн Дуламсүрэн - Төв аймгийн статистикийн хэлтсийн ахлах статистикч
6. Очирын Доржраа - Монголын ховор амьтдыг хамгаалах үндэсний комиссын нарийн бичгийн дарга
7. Цэрэндоржийн Доржхүү - Зэвсэгт хүчний Хяналт-шалгалт үнэлгээний газрын дарга, хурандаа
8. Лувсанбалдангийн Жигжидсүрэн - УБТЗ-ын Барилга орон сууцны 1 дүгээр ангийн дарга

9. Лутын Лханям - Увс аймаг дахь Хөдөлмөрийн дээд сургуулийн эдийн засгийн багш
10. Лодойн Пүрэвгял - Баянхонгор аймаг дахь уул уурхайн "Монгол болгаргео" ХХК-ийн гүйцэтгэх захирал
11. Доржийн Пүрэвжав - УБТЗ-ын Зам засварын машин станцын дарга
12. Базардарийн Равдан - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Жаргалант тосгоны эмнэлгийн ерөнхий эмч
13. Лхамсүрэнгийн Төмөр - Нийслэлийн барилга, угсралт, засварын "Ордос" ХХК-ийн захирал
14. Цэвээнсамбуугийн Цэндсүрэн - Хэнтий аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эрхлэгч
15. Бэрэнбаралийн Эрдэнэбилэгт - Монгол Улсаас ОХУ-д суугаа ЭСЯ-ны худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан ажилтан

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Батхуягийн Батсайхан - ТТХГ-ын Хангалтын албаны дарга, хурандаа

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Будрагчаагийн Авирмэд - УБТЗ-ын Дохиол холбооны 2 дугаар ангийн холбооны механикч
2. Лхамрагчаагийн Алтанцэцэг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн бага ангийн багш

3. Сангидоржийн Баасандорж - "МИАТ" ХК-ийн В-737-800 онгоцны дарга
4. Баянхүүгийн Аюушжав - Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн поликлиник хариуцсан дэд захирал

5. Цогоогийн Баасандорж - М-Си-Эс интернэйшнл ХХК-ийн дэд бүтэц хариуцсан дэд захирал
6. Даваажавын Бауу - Нийслэлийн Хан-Уул дүүргийн өндөр настан, төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан
7. Пүрэвдаваагийн Байгалжав - Нийслэлийн хөгжмийн зэмсэг үйлдвэрлэлийн "Эгшиглэн Магнай" ХХК-ийн ерөнхий захирал
8. Дуламсүрэнгийн Батболд - Нийслэлийн барилгын "Ган Татанга" ХК-ийн ерөнхий захирал
9. Ванганжальын Батмагнай - Завхан аймгийн Сонгино сумын Засаг дарга
10. Дүгэрийн Батнасан - Ховд аймгийн Нисэх буудлын дарга
11. Шинэнбалжийн Батсайхан - Сүхбаатар аймгийн Тэмүүлэл цогцолбор сургуулийн дуу хөгжмийн багш
12. Дуламжавын Батсүрэн - ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч
13. Цэвэгсүрэнгийн Батхуяг - Хошин урлагийн Комеди-Арт хамтлагийн жүжигчин
14. Махрэнцэнгийн Баярхүү - Нийслэл дэх "Гурван тамир" бүрэн дунд сургуулийн биеийн тамирын багш
15. Балдан-Осорын Буд - МУЭ-ийн хорооны уран бүтээлч, чимэглэх урлагийн зураач
16. Лувсангомбын Бямбажав - "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн шугамын монтер
17. Мишигийн Бямбарагчаа - Монгол Цэргийн музейн сан хөмрөгч-менежер
18. Ядамцоогийн Гийхнаран - Нийслэлийн Багануур дүүрэг дэх "Сод" бүрэн дунд сургуулийн бага ангийн багш
19. Луузангийн Гомбосүрэн - Сүхбаатар аймгийн Хөгжимт жүжгийн театрын ерөнхий найруулагч
20. Жүгдэрнамжилын Гэрэлтбямба - УБТЗ-ын Захиран хуваарилах хэлтсийн галт тэрэгний ахлах зохицуулагч
21. Дамиранжавын Дамдин - Төв аймгийн УАА-н "Тунгалаг-Ус" ХХК-ийн бригадын дарга
22. Гочоогийн Дамдинрагчаа - Нийслэлийн барилгын "Хатанбаатар" ХХК-ийн зөвлөх инженер
23. Намжилдоржийн Дашням - Төв аймгийн Борнуур сумын эмнэлгийн дотрын их эмч
24. Ганиагийн Долмаа - ШУА-ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
25. Биндэръяагийн Долгорсүрэн - Улаанбаатар дахь вагон депогийн зорчигчийн вагоны үйлчлэгч
26. Цэндийн Дондоо - Булган аймгийн Дашинчилэн сумын малчин
27. Санчирын Доржханд - Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн сувиллагч
28. Сэдэдийн Жаргалсайхан - УБТЗ-ын Дохиолол холбооны 2 дугаар ангийн дарга
29. Оригийн Жинхүү - Төв аймгийн Авто замын засвар арилталын компанийн замчин
30. Чойжилсүрэнгийн Зоригтбаатар - Сүхбаатар аймгийн НААУ-ний "Дөрвөлж" ОНӨҮГ-ын механикч
31. Дугаржавын Ира - Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Статистикийн газрын мэргэжилтэн
32. Ишдоржийн Лхагвасүрэн - УБТЗ-ын Авто тээвэр, үйлчилгээний төвийн жолооч
33. Мөнхбаярын Мандах - Баянхонгор аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" ХК-ийн ерөнхий инженер
34. Нямдоржийн Мядагмаа - Өмнөговь аймгийн "Эм хангамж" ХХК-ийн захирал
35. Бадамсүрэнгийн Нагнайдорж - Кино найруулагч
36. Нацагдоржийн Надмид - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны иргэн, ахмад мал зүгч
37. Чойндонгийн Нарантуяа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 53 дугаар сургуулийн нийгмийн ажилтан
38. Чойжамцын Наранцэцэг - Булган аймгийн Бүрэгхангай сумын дунд сургуулийн захирал
39. Дамбын Нямхүү - Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн чих хамар хоолойн их эмч
40. Нанжидын Онон - Хошин урлагийн "Х-Түц" уран бүтээлийн нэгдлийн жүжигчин
41. Доржготовын Отгонлоос - Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын хүн эмнэлгийн эх барих бага эмч
42. Шагдарсүрэнгийн Пунцагдэлэг - УБТЗ-ын Удирдах газрын хяналтын албаны улсын байцаагч
43. Энэбишийн Пүрэвдаваа - ЭМЯ-ны харьяа Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн тасгийн эрхлэгч
44. Нацагдоржийн Пүрэвдорж - Дорноговь аймгийн "Саран хөхөө" театрын ерөнхий найруулагч
45. Цамбын Пүрэвдорж - УБТЗ-ын авто тээвэр үйлчилгээний төвийн жолооч
46. Дагвадоржийн Пүрэвдорж - ГХЯ-ны ДБУААГ-ын жолооч
47. Дамдинжавын Пүрэвсүрэн - Хадгаламж банкны тооцооны 37 дугаар төвийн захирал
48. Намсрайн Сандагдорж - Нийслэлийн Хан-Уул дүүрэг дэх мод үржүүлгийн "Авдрын уулын гол овоо" нөхөрлөлийн тэргүүн
49. Сандуйжавын Санжаабямба - Улсын Клиникийн төв эмнэлгийн мэс заслын клиникийн зөвлөх эмч
50. Бат-Очирын Сарандаваа - Бясалгал, зурхай, сүнс, сэтгэл судлалын академийн тэргүүн
51. Цагааны Сувд - ТЗҮААЭГ-ын санхүү бүртгэлийн мэргэжилтэн
52. Сэнгээгийн Сугир - Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн шинжлэгч эмч



53. Лхүндэвийн Сэнгээ - УБТЗ-ын "Ган зам" сонин хэвлэх үйлдвэрийн дарга

54. Төртөгтохын Тулгаа - Нийслэлийн ОСНАА-н "Сансар-Өргөө" СӨХ-ны гүйцэтгэх захирал

55. Гомбосүрэнгийн Түмэн-Өлзий - УБТЗ-ын Шугам замын худалдааны төвийн дарга

56. Чойжилжавын Цогтбаяр - УБТЗ-ын Дохиолол холбоо, мэдээлэл, эрчим хүчний албаны дарга

57. Чимэдрэгзэнгийн Цогт-Очир - ЭМШУИС-ийн багш

58. Чимэдийн Цэгмэд - Хөвсгөл аймгийн Их-Уул сумын иргэн, ахмад тээвэрчин

59. Агвааны Цэдэн - УБТЗ-ын тээврийн хяналтын албаны улсын ахлах байцаагч

60. Бидэрьяагийн Цэрэнханд - Үндэсний

Статистикийн хорооны Мэдээлэл боловсруулалт, технологийн газрын дарга

61. Намидын Шагдар - Хэнтий аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн инженер

62. Намсанжаагийн Энхтуяа - Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн багш

63. Любагийн Эрдэнэчулуун - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургуулийн захирал

64. Лувсанданзангийн Эрдэнэбаяр - Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчин, усны асуудал хариуцсан улсын ахлах байцаагч

65. Бадамцэрэнгийн Эрдэнэнамжилмаа - Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

66. Чүлтэмийн Ядамсүрэн - УБТЗ-ын Толгойт өртөөний дарга

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Гүнчингийн Батсүрэн - БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн тэнхимийн багш, хурандаа

2. Банзрагчийн Пүрэвсүрэн - Дорноговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн ахлах байцаагч, тэргүүн ахмад

3. Мангалжавын Равдандорж - Өмнөговь аймгийн худалдаа үйлчилгээний "Хөвөн хайрхан" ХХК-ийн захирал, ахмад мөрдөн байцаагч

4. Дугаржавын Рэнцэндорж - ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

5. Лундаагийн Хуягбаатар - Төв аймгийн цагдаагийн газрын аж ахуйн нярав, бэлтгэл ахмад

6. Төмөрийн Энхбаатар - Өвөрхангай аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дамбаравчигийн Авирмэд - Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

2. Баярмагнайн Алтангэрэл - Ховд аймгийн ХДТ-ын хөгжимчин

3. Сайндайн Алтанхундага - Увс аймгийн Аудитын газрын ахлах аудитор

4. Цэрэндоржийн Амарсайхан - ХААИС-ийн нийгэм, эдийн засгийн асуудал эрхэлсэн проректор

5. Амгаагийн Атарбаяр - Төв аймгийн Угтаалцайд сумын хүн эмнэлгийн сувилагч

6. Хаймчигийн Аюуш - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авто баазын диспетчер-механик

7. Гүржавын Баасанжав - УБТЗ-ын Дархан дахь татах хэсгийн машинч

8. Чүлтэмийн Баасанжав - Онцгой байдлын ерөнхий газрын автобаазын жолооч

9. Намхайдоржийн Баатаржав - УБТЗ-ын эрчим хүч, ус хангамжийн 1 дүгээр ангийн дарга

10. Лувсангомбын Баатарчулуун - УБТЗ-ын 4 дүгээр ангийн гүүрийн мастер

11. Чамейханы Багал - Ховд аймгийн Татварын хэлтсийн дарга

12. Пунцагдоржийн Бадамдорж - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн уурын зуухны механикч

13. Ламжавын Батмөнх - ХААИС-ийн тэнхимийн эрхлэгч

14. Пүрэвийн Батчулуун - Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг дарга

15. Пагмын Бат-Эрдэнэ - УБТЗ-ын гадаад харилцааны албаны орлогч дарга

16. Муухайн Баясгалан - "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн ахлах мэргэжилтэн

17. Дашхүүгийн Болд - Говьсүмбэр аймгийн уул уурхайн "Говьго" ХХК-ийн өрмийн инженер

18. Ламжавын Болд - УБТЗ-ын Удирдах газарт Вагоны аж ахуйн албаны дарга

19. Хянгарадын Болд - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

20. Цэрэнтогтохын Буяндорж - Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Хөтөлийн гавшгай ус" ХХК-ийн машинист

21. Дамдиндонойн Буянжаргал - Зэвсэгт хүчний Клиникийн төв эмнэлгийн поликлиникийн сувилагч

22. Цэдэндамбын Будханд - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч

23. Дамцаагийн Бүүвэй - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн халуун угаалгын газрын эрхлэгч

24. Варламова Татьяна Степановна - УАШУТ Корпорацийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

25. Бадрахын Галсанцэдэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч

26. Давдайн Ганбат - Нийслэлийн Эрүүл мэндийн газрын түргэн тусламжийн жолооч
27. Доржсүрэнгийн Ганбат - УБТЗ-ын Улаанбаатар зүтгүүрийн депогийн машинч
28. Чулуунбаатарын Ганбилэг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн сургалтын менежер
29. Чимэдцэрэнгийн Ганжамбал - УБТЗ-ын Сайншанд дахь татах хэсгийн машинч
30. Алтангэрэлийн Гантөмөр - Улсын Клиникийн төв эмнэлгийн нүд судлалын клиникийн сувилагч
31. Мэндбаярын Гомбосүрэн - Завхан аймгийн Цагаанхайрхан сумын хүн эмнэлгийн Баянбулаг багийн бага эмч
32. Цэндхүүгийн Гэрэлцэцэг - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэрэг, архивын эрхлэгч
33. Лувсангомбын Гэрэлчулуун - Сэлэнгэ аймгийн Сант сумын сум дундын хүн эмнэлгийн эх баригч бага эмч
34. Замбын Дамдинсүрэн - Дархан-Уул аймаг дахь "Дархан дулааны сүлжээ" ХК-ийн жолооч
35. Лувсандашийн Дамдинсүрэн - Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч
36. Лодонгийн Дашням - УБТЗ-ын Удирдах газрын хөдөлмөр хамгааллын хэлтсийн дарга
37. Балдандоржийн Довддорж - Гаалийн ерөнхий газрын санхүү, эдийн засгийн газрын орлогч дарга
38. Товуугийн Доржсүрэн - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын багийн Засаг дарга
39. Баасанжавын Дугармаа - Ховд аймгийн Жаргалант сумын 11 жилийн 3 дугаар сургуулийн түүх-нийгмийн багш
40. Пүрэвдоржийн Дулам - Улаанбаатар хот дахь Хүнсний нөөцийн салбарын нярав
41. Банзрагчийн Дэмбэрэл - Говьсүмбэр аймгийн уул уурхайн "Говьгео" ХХК-ийн өрмийн мастер
42. Янчааны Ичинхорлоо - Улсын Клиникийн төв эмнэлгийн нүд судлалын клиникийн сувилагч
43. Сундуйн Жавзан - Говь-Алтай аймгийн "Хараат хайрхан" харшооны эзэн, оёдолчин
44. Дашмядагийн Зоригт - Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрийн бригадын дарга
45. Цэенгийн Лхагвадулам - Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн нүүр амны эмч
46. Самбуугийн Лхагважав - Ховд аймгийн Жаргалант сумын ногоочин
47. Цэндийн Лхагвасүрэн - Хэнтий аймгийн Галшар сумын мал аж ахуйн "Гал-Сүм" ХХК-ийн захирал
48. Чойжилын Миехиддорж - УБТЗ-ын хүний нөөцийн удирдлагын албаны дарга
49. Ядамын Мөнхбаяр - Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Атар-Өргөө" ХК-ийн автогражийн дарга
50. Сэнгийн Мөнхтоогоо - Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ эм хангамж" ХХК-ийн захирал
51. Очирхуягийн Мөнхтогтох - Улсын филармонийн "Морин хуур" чуулгын хөгжимчин
52. Өнөбаярын Мунгаа - Сүхбаатар аймгийн Онгон сумын Шуудан холбооны шууданч
53. Баттулгын Мягмар - Гаалийн ерөнхий газрын гаалийн улсын байцаагч
54. Жигмэдийн Мягмарсүрэн - Архангай аймгийн Онцгой байдлын хэлтсийн аврагч отрядын аврагч-химичин, дээд түрүүч
55. Намдагийн Намсрай - Увс аймгийн Өлгий сумын Засаг дарга
56. Балжиннямын Намуугүрвэ - Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, эмч
57. Цэрэндоржийн Нарантулгал - УИХ-ын Тамгын газрын гадаад харилцааны хэлтсийн дарга
58. Чүлтэмийн Нарантулгал - Булган аймгийн Хутаг-Өндөр сум дахь Улсын нөөцийн салбарын дарга, дээд дэслэгч
59. Нямхүүгийн Наранцацрал - Улсын Клиникийн төв эмнэлгийн гемодиализийн төвийн сувилагч
60. Надмидын Наранццэцэг - Нийслэлийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
61. Очирболдын Наранццэцэг - Сүхбаатар аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч
62. Цэндийн Нацагдорж - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын дунд сургуулийн математикийн багш
63. Дөвчинжавын Норолхоо - Нийслэл дэх шүдний "Од хийморь" хувийн эмнэлгийн их эмч
64. Дээдээгийн Нэргүй - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн сувилагч
65. Сангишаравын Ням - Баянхонгор аймаг дахь Улсын нөөцийн салбарын дарга, шадар ахмад
66. Юмжээгийн Нямжаргал - УБТЗ-ын орлогч дарга, тээврийн ерөнхий байцаагч
67. Лхамжавын Отгон - Сүхбаатар аймгийн Тэмүүлэл цогцолбор сургуулийн бага ангийн багш
68. Жанрайн Отгонбаяр - УБТЗ-ын өртөөний ачаа вагон хүлээлэгч
69. Цэрэнгийн Отгонжаргал - Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын кино механикч
70. Батдоржийн Оюун - Нийслэлийн Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийн технологийн багш
71. Цэмбэлдоржийн Оюун - Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын архивын албаны дарга
72. Самбуудоржийн Оюунчимэг - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч
73. Сосорбарамын Оюунчимэг - Нийслэлийн Соёл урлагийн газрын мэргэжилтэн
74. Пунцагийн Пүрэвэ - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш

75. Цэнд-Аюушийн Пүрэвжав - УАШУТУ Корпорацийн клиник эмнэлгийн лаборант

76. Зиядабекин Рина - Гаалийн ерөнхий газрын ерөнхий нягтлан бодогч

77. Дамдиндоржийн Роза - УБТЗ-ын Техникийн Бодлогын албаны улсын байцаагч

78. Агвааны Сайнбилэг - Ховд аймгийн ХДТ-ын хөгжимчин

79. Чимэдийн Сүнжидмаа - Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий сувилагч

80. Дамбажанцангийн Сүрэнбат - Булган аймгийн Рашаант сумын дунд сургуулийн математикийн багш

81. Мядагийн Сүрэнхүү - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн хүнсний нярав

82. Гомбосүрэнгийн Сэрээндорж - УБТЗ-ын Удирдах газарт ерөнхий инженер

83. Осорын Тайван - УБТЗ-ын Ачаа тээврийн албаны ахлах байцаагч

84. Сэдэдийн Төмөрсүх - ХХААХҮЯ-ны архив бичиг хэргийн эрхлэгч

85. Баянгийн Туул - УБТЗ-ын Улаанбаатар техник үйлчилгээний газрын вагон үзэгч

86. Естийн Халтар - Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын аж ахуйн нярав

87. Банарачийн Хоролотов - УБТЗ-ын Олон улсын тээвэр зуучлалын төвийн эдийн засагч

88. Лосолын Хорхой - Булган аймгийн Хангал сумын 2 дугаар багийн малчин

89. Шараагийн Цогтбаяр - Говьсүмбэр аймгийн уул уурхайн "Говьгео" ХХК-ийн өрмийн мастер

90. Сайнжаргалын Цогтсайхан - УБТЗ-ын аялал жуулчлалын товчооны захирал

91. Нямхүүгийн Цэгмэд - Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн дотор, арьсны клиникийн сувилагч

92. Хандын Цэндөө - Дархан-Уул аймгийн "Эрэл" цементийн үйлдвэрийн ерөнхий нягтлан бодогч

93. Ойдовын Цэрэнгаваа - Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн халдварын сувилагч

94. Нацагдоржийн Цэрэндолгор - Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн хагалгааны сувилагч

95. Гэндэнгийн Цэрэндулам - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хорооны Засаг дарга

96. Дэлхаагийн Цэцгээ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

97. Маналжавын Цэцэгмаа - Хэнтий аймгийн Биндэр сумын хүн эмнэлгийн сувилагч

98. Гомбосүрэнгийн Чимиддорж - Сүхбаатар аймгийн Онгон сумын дунд сургуулийн бага ангийн хичээлийн эрхлэгч

99. Жанчивдоржийн Чулуунхүү - УБТЗ-ын Сайншанд дахь гал унтраах ангийн ачаа хамгаалагч

100. Доржпаламын Энхбаяр - ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн аж ахуйн дарга

101. Хайнзангийн Энхбаяр - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн нярав

102. Лосройн Энхболд - УБТЗ-ын Дорнод аймаг дахь Баянтүмэн тасгийн дарга

103. Жамсрандоржийн Энхтайван - Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Баянзүрх эмнэлэг" -ийн орлогч дарга

104. Дүгэрсүрэнгийн Энхтуяа - Төмөр замын дээд сургуулийн химийн багш

105. Жүгдэрийн Энхтуяа - УБТЗ-ын Улаанбаатар дахь Вагон депогийн токарчин

106. Чойгийн Энхтүвшин - Зэвсэгт хүчний Клиникийн төв эмнэлгийн эмгэгтэйчүүдийн кабинетын сувилагч

107. Дамдинжавын Эрдэнэцэцэг - Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

108. Дуламсүрэнгийн Эрдэнэчимэг - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичээч

109. Батхишигийн Эрдэнэчулуун - Хараагүй хүмүүсийн хөдөлмөр суртал үйлдвэрлэлийн нормчин

110. Раднаабазарын Ягаанцэцэг - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

111. Огоогийн Янжмаа - Нийслэлийн Налайх дүүргийн "Голомт" цогцолбор сургуулийн монгол хэл уран зохиолын багш

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сандагийн Баттөр - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн холбооны зангилааны дарга, хошууч

2. Лугаагийн Бямбажав - Талуулын ерөнхий газрын авто баазын ерөнхий инженер

3. Шагдарын Ганболд - Онцгой байдлын ерөнхий газрын Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дээд ахмад

4. Доржийн Даваабаяр - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн засварын дарга-инженер, хошууч

5. Нацагийн Дашпунцаг - Нийслэлийн Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

6. Жавзмаагийн Дуламцэрэн - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, ахлах ахлагч

7. Жамъяны Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн техникийн бага мэргэжилтэн

8. Мянгарсүрэнгийн Оюун - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга-жолооч, ахлах ахлагч

9. Лувсангийн Пүрэвхүү - Онцгой байдлын ерөнхий газрын Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дээд ахмад

10. Дэлэбазарын Сүхбат - Онцгой байдлын ерөнхий газрын Тамгын газрын дарга, тэргүүн ахмад

11. Барамсайн Төмөрчөдөр - Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах 37 дугаар ангийн салааны захирагч, тэргүүн дэслэгч

12. Доржготовын Ууганбаяр - Булган аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

13. Даншийн Чинбат - Хөвсгөл аймаг дахь Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа

14. Ядамдоржийн Чулуунбаатар - Увс аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

15. Ядамдоржийн Эрдэнэбилэг - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн тусгай тоноглолын механик-жолооч, ахлах ахлагч

16. Бямбасүрэнгийн Энхтүвшин - Завхан аймгийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах 39 дүгээр ангийн жолооч, дээд түрүүч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 11 дүгээр
сарын 21-ний өдөр**

Дугаар 339

**Улаанбаатар
хот**

Зарим хүнийг "Энхийн төлөө" медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний цэргийн багийн хамтарсан "Дархан-1" Энхийг сахиулах ажиллагааны сургалт, дадлагад онц идэвхи зүтгэл гарган оролцож, үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн

Монгол Улсын Зэвсэгт хүчний болон ОХУ-ын Зэвсэгт хүчний зарим тэргүүний генерал, офицер, ахлагч нарыг "Энхийн төлөө" медалиар шагнасуугай.

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИАР:

1. Сэрээнэнгийн Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагч, хурандаа

2. Пагчигийн Буянтогтох - Батлан хамгаалах яамны харьяа "Транс-сэргэлт" ХХК-ийн дэд захирал, бэлтгэл хурандаа

3. Лувсандоржийн Эрдэнэбилэг - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, дэд хурандаа

4. Дэмбэрэлийн Сэргэлэнцогт - Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа

5. Тогтохын Алтангэрэл - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн агрегатын засварчин, ахлах ахлагч

6. Цэрэндоржийн Гиваа - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн механик жолооч, ахлах ахлагч

7. Хандын Оросоо - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын професс хангах ротын техникийн орлогч, ахлах ахлагч

8. Пүрэвдоржийн Отгонбаяр - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн зэвсгийн засварчин, дэд ахлагч

9. Коновалов Василий Робертович - Сибирийн цэргийн тойргийн Хуягт танкийн албаны дарга, хошууч генерал

10. Иванчиков Алексей Алексеевич - Сибирийн цэргийн тойргийн Зэвсэглэл, техникийн газрын штабын даргын орлогч, хурандаа

11. Акимов Михаил Алексеевич - Сибирийн цэргийн тойргийн Зэвсэглэл, техникийн газрын штабын автоматжуулалтын тасгийн дарга, хурандаа

12. Оленников Константин Николаевич - Сибирийн цэргийн тойргийн Хэмжил зүйн албаны дарга, дэд хурандаа

13. Левицкий Александр Евгеньевич - Сибирийн цэргийн тойргийн пуужин, артиллерийн зэвсэглэлийн хэлтсийн ахлах офицер, дэд хурандаа

14. Старокоров Сергей Николаевич - Сибирийн цэргийн тойргийн Зэвсэглэл техникийн газрын даргын хүмүүжил эрхэлсэн туслах, дэд хурандаа

15. Федоренко Андрей Павлович - Сибирийн цэргийн тойргийн 96516 дугаар ангийн тасгийн дарга, дэд хурандаа

16. Кузьмицкий Виталий Николаевич - Сибирийн цэргийн тойргийн Цэргийн төмөр замын тээвэрлэлтийн хэлтсийн даргын орлогч, хошууч

17. Мочалов Павел Юрьевич - Сибирийн цэргийн тойргийн Хэмжил зүйн баазын дарга, дэд хурандаа

18. Ковальчук Анатолий Алексеевич - Сибирийн цэргийн тойргийн 63753 дугаар ангийн захирагч, хурандаа

19. Гергало Юрий Николаевич - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн захирагчийн зэвсэглэл эрхэлсэн орлогч, дэд хурандаа

20. Шеремета Вадим Николаевич - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн авто засварын дарга, дэд хурандаа

21. Есьман Александр Юрьевич - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн пуужин, артиллерийн зэвсэглэлийн дарга, дэд хурандаа

22. Макаренко Андрей Александрович - Сибирийн цэргийн тойргийн 93757 дугаар ангийн захирагчийн зэвсэглэл, эрхэлсэн орлогч, ахмад

23. Семенов Валерий Варерьевич - Сибирийн цэргийн тойргийн 07342 дугаар ангийн автотехникийн засварын дарга, хошууч

24. Гончаренко Юрий Иванович - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн захирагч, хурандаа

25. Ватулин Юрий Анатольевич - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн хуягт танкийн засварын дарга, дэд хурандаа

26. Фетискин Сергей Владимирович - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн ротын захирагч, ахмад

27. Селиванов Вадим Павлович - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн татан гаргах батальоны захирагч, ахмад

28. Черешко Леонид Игоревич - Сибирийн цэргийн тойргийн 48885 дугаар ангийн автотехникийн засварын ротын дарга, дэслэгч

29. Арепьев Александр Леонидович - Сибирийн цэргийн тойргийн 31965 дугаар ангийн ротын техникийн орлогч, ахлах ахлагч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд П.Очирбат, Ж.Амарсанаа, Ж.Болдбаатар, Д.Наранчимэг/илтгэгч/, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар С.Энхтуулг орлоцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д.Батсүх, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагадагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно" гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хэлэлцээд хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн 27 дугаар тогтоол гаргаж ирүүлсэнтэй холбогдуулан уг маргааны дахин хянаж эцэслэн шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Батсүх Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдаж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг олноо зарлан тунхагласан билээ.

Үндсэн хуулийн энэхүү үзэл санааны хүрээнд иргэний эдлэх эрх, эрх чөлөөг баталгаатай хангахад хууль зүйн мэргэжлийн туслалцааны агуулга, мөн чанарыг тодорхойлж өгснөөрөө ардчилсан нийгмийн үнэт зүйлийг баталгаажуулсан юм.

Үүний тод илрэл бол Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "...1.Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй...", 2 дахь хэсэгт "...Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ..." хэмээн заасан байна.

Хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй..." хэмээн иргэний Үндсэн эрхтэй холбогдуулан баталгаажуулжээ.

Үндсэн хуулийн дээрх заалтыг улам бүр баталгаажуулж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "өмгөөлөгч нь ...хууль зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй," мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.7, 36 дугаар зүйлийн 36.3.3-д өмгөөлөгч авах эрхтэйг тус тус заажээ.

Гэтэл 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "...Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагадагч, шүүгдэгч өөрөө

өмгөөлөгчөөр сонгоно..." хэмээн заасан нь Үндсэн хуулийн дээрх үзэл санааг зөрчсөн төдийгүй Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах боломжийг хааж, мэргэжлийн хууль зүйн туслалцааны үнэ цэнэ, агуулга, ач холбогдлыг алдагдуулж байна.

Өөрөөр хэлбэл харшлах шалтгаангүй хэн боловч Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох болохоор ойлгогдож байгаа юм.

Түүнчлэн мэргэжлийн бус хүмүүс Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцож, хууль зүйн мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт гаргаж чадахгүй, үр нөлөөтэй хууль зүйн туслалцаа үзүүлж чадаагүйнхээ төлөө мэргэжлийн болон ёс зүйн ямар ч хариуцлага хүлээхгүй байгаа нь иргэний эрх зүйн байдлыг дордуулан хохирооход хүргэж байна.

Үндсэн хуулийн дээрх зөрчлийг арилгах нь хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хамгаалах, шүүх эрх мэдлийн нэр хүндийг өргөж, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлдэх чухал нөлөө үзүүлэх юм. ...

Дээр дурдсан тайлбар, үндэслэлүүдээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...өерийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах...эрхтэй..." гэснийг, Тавин тавдугаар зүйлийн "1. Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй. 2. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хусэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байгаа талаар дүгнэлт гаргаж өгөхийг хүсье." гэжээ.

Хойр. Улсын Их Хурлын даргын 2008 оны 9 дугээр сарын 19-ний өдрийн 83 дугаар захирамжаар томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"...1. Хүний эрхийг хангах баталгааны чухал бүрэлдэхүүн хэсэг бол өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх бөгөөд Үндсэн хуулиар үүнийг баталгаажуулж өгсөн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалтыг дангаар нь авч үзэх боломжгүй бөгөөд хуулийн бусад заалтуудтай уяалдуулан авч үзэх хэрэгтэй юм. Хүн өөрийгөө өмгөөлөх эрхтэйгээс гадна өмгөөлөгчөө өөрөө сонгох, солих эрхтэй бөгөөд энэ нь тухайн этгээдийн чөлөөт сонголтгоор шийдвэрлэгдэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39.1-д "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгоно." гэж заасан. Шүүх энэ эрхийг хангах боломжийг бүрдүүлж өгөх ёстой. Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй тохиолдолд өөрөө итгэж байгаа, өөртөө хэрэгтэй тэр туслалцааг үзүүлж чадна гэсэн этгээдийг сонгож, өмгөөлүүлэх эрхээ эдлэх боломжийг мөн хуулийн заалтаар олгож байгаа юм.

Нэн даруй хууль зүйн туслалцаа авах нь өөрийгөө хамгаалуулах эрхээ хангах урьдчилсан нөхцөл болно. Иймд хуулийн дээрх заалт иргэн Д.Батсүхийн тайлбарласнаар "сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэргэжлийн хууль зүйн туслалцаа авах боломжийг хааж, мэргэжлийн хууль зүйн туслалцааны үнэ цэнэ, агуулга, ач холбогдлыг алдагдуулж байна." гэж үзэж болохгүй юм.

2. Харин ч мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй тухайн тохиолдолд шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөө сонгож авснаар өөрийгөө өмгөөлөх эрх нь бас давхар баталгаажиж байгаа юм. Энэ тохиолдолд иргэний эрх зүйн байдлыг дордуулан хохироход хүргэж байгаа бий эсрэгээрээ давхар хамгаалалттай болох нөхцөл бүрдэж байгаа юм. Хууль тогтоогч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль ёсыг дээдлэн хэрэгжүүлэх нөхцөл хангагдах ёстой гэж үзэж энэ заалтыг зурлуулсан болно.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн заалт нь Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хусэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...хууль зүйн туслалцаа авах...эрхтэй..." гэсэн хэсгийг зөрчсөн гэх үндэслэлгүй байна." гэжээ.

Гурав: Уг маргааныг Үндсэн хуулийн цэц дунд суудлын хуралдаанаараа 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдөр хэлэлцэж хуулийн дээрх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна гэсэн 07 дугаар дүгнэлт гаргасан байна. Дүгнэлтэд:

"Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно" гэсэн заалт нь хууль зүйн боловсролгүй, хуульчийн сонгон шалгаруулалт болон өмгөөлөгчийн мэргэжлийн шалгаруулалтад орж тусгай зөвшөөрөл аваагүй иргэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн эрхтэйгээр оролцох хууль зүйн үндэслэл бий болгосноор байцаан шийтгэх ажиллагаанд оролцох байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн Үндсэн хуульд заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах эрхийг хангах боломжийг хязгаарласан байна.

Аливаа иргэн мэргэжлийн өмгөөлөгчийн эрх эдэлж, үүрэг биелүүлж, хариуцлага хүлээн өмгөөлөгчийн талаар гаргасан хууль, журмыг мөрдөж, байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжгүй юм. 1994 оны Өмгөөллийн тухай хуулийг 2002 онд шинэчлэн найруулахдаа дээрх заалтыг

хассан боловч Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шилжүүлэн нэмж оруулсан нь ойлгомжгүй байна гээд дээрх заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь заалтын холбогдох хэсгийг зөрчсөн байна" гэжээ.

Дөрөө: Үндсэн хуулийн цэцийн 07 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хэлэлцээд хүлээн зөвшөөрөх боломжгүй байна гэсэн Улсын Их Хурлын 27 дугаар тогтоол гаргасан байна.
Уг тогтоолд:

"1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "...хууль зүйн туслалцаа авах ...эрхтэй...", Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэжээ.

Тав: Цэцийн их суудлын хуралдаанд Улсын Их Хурлын даргын 2008 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 134 тоот захирамжаар томилгдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Үндсэн хуулийн цэцэд өмнө нь ирүүлсэн тайлбараа дэмжиж байна гэсэн агуулга бүхий тайлбарыг ирүүлсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно." гэсэн заалт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор хууль зүйн боловсролгүй, мэргэжлийн хууль бус дурын этгээд оролцох боломжийг бий болгосноор иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах Үндсэн хуулиар бэхжүүлсэн баталгааг дордуулсан байна.

Ингэснээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь заалтын үзэл санаатай эерчилдэг байна.

2. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай үндэслэл, нотолгоог гаргаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг; Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх заалт; Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2; 32 дугаар зүйлийн 2 дахь заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Мэргэжлийн өмгөөлөгч оролцох боломжгүй бол байцаан шийтгэх ажиллагаанд оролцоход харшлах шалтгаангүй этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө өмгөөлөгчөөр сонгоно." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/-ийн "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй..."; Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ..." гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай.

2. Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 27 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү шийдвэр нь эсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

П.ОЧИРБАТ

Ж.АМАРСАНАА

Ж.БОЛДБААТАР

Д.НАРАНЧИМЭГ

Ц.САРАНТУЯА

Д.МӨНХГЭРЭЛ

Б.ПҮРЭВНЯМ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1.5